



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Хяналтын хуудас батлах тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 479 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Хяналт шалгалт хийх нийтлэг журмын 16.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Зам, тээврийн салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэх авто тээврийн хяналтын чиглэлээр 04.1.1 кодтой Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг эрхлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 1 дүгээр, 04.1.2 кодтой Авто тээврийн хэрэгслийн авто засвар, үйлчилгээний үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 2 дугаар, 04.1.3 кодтой Авто тээврийн хэрэгслийн кузов засвар, үйлчилгээний үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 3 дугаар, 04.1.4 кодтой Авто тээврийн хэрэгслийн авто угаалга, үйлчилгээний үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 4 дүгээр, 04.1.5 кодтой Авто тээврийн хэрэгслийн резин дугуй засварын үйлчилгээний үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 5 дугаар, 04.1.6 кодтой Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 6 дугаар, 04.1.7 кодтой Аюултай ачаа тээврийн автомашин /чиргүүл/-ыг шалгах хяналтын хуудсыг 7 дугаар, 04.1.8 кодтой Ачаа тээврийн автомашин /чиргүүл/-ыг шалгах хяналтын хуудсыг 8 дугаар, 04.1.9 кодтой Ачаа тээвэрлэлтийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсыг 9 дүгээр, 04.1.10 кодтой Нийтийн тээврийн үйлчилгээний байгууллагыг шалгах хяналтын хуудсыг 10 дугаар, 04.1.11 кодтой Жуулчны тээврийн үйлчилгээний автотээврийн хэрэгслийг шалгах хяналтын хуудсыг 11 дүгээр, 04.1.12 кодтой Суудлын автомашиныг шалгах хяналтын хуудсыг 12 дугаар, 04.1.13 кодтой Такси үйлчилгээний автотээврийн хэрэгслийг шалгах хяналтын хуудсыг 13 дугаар, 04.1.14 кодтой Хүүхэд тээвэрлэх автобусыг шалгах хяналтын хуудсыг 14 дүгээр, 04.1.15 кодтой Нийтийн тээврийн үйлчилгээний автотээврийн хэрэгслийг шалгах хяналтын хуудсыг 15 дугаар, 04.1.16 кодтой Тусгай үйлчилгээний авто тээврийн байгууллага, объектыг шалгах хяналтын хуудсыг 16 дугаар, 04.1.17 кодтой Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 17 дугаар, Авто замын хяналтын чиглэлээр 04.2.1 кодтой Гүүрийн угсралт, шинэчлэлт, их болон ээлжит засварын ажлыг шалгах хяналтын хуудсыг 18 дугаар, 04.2.2 кодтой Гүүрийн арчлалт хамгаалалт, урсгал засварын ажлыг шалгах хяналтын хуудсыг 19 дүгээр, 04.2.3 кодтой Авто замын угсралт, шинэчлэлт, их болон ээлжит засварын ажлыг шалгах хяналтын хуудсыг 20 дугаар, 04.2.4 кодтой Авто замын арчлалт хамгаалалт, урсгал засварын ажлыг шалгах хяналтын хуудсыг 21 дүгээр, 04.2.5 кодтой Агаарын хөлгийн хөөрч буух зурвас, явгалах зам, перрон, зогсоол болон бусад зам талбайн угсралт, шинэчлэлт, засварын ажлыг шалгах хяналтын хуудсыг 22 дугаар, 04.2.6 кодтой Авто зам, замын байгууламжийн техник, технологийн хяналт гүйцэтгэх ажлыг шалгах хяналтын хуудсыг 23 дугаар, 04.2.7 кодтой Авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдлыг шалгах хяналтын хуудсыг 24 дүгээр, 04.2.8 кодтой Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд ашиглах материал, бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, заводын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 25 дугаар, 04.2.9 кодтой Авто зам, замын байгууламжийн зураг төсөл

080000103

зохиогч байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 26 дугаар, Төмөр замын хяналтын чиглэлээр 04.3.1 кодтой Төмөр замын байгууламжийг шалгах хяналтын хуудсыг 27 дугаар, 04.3.2 кодтой Төмөр замын дохиоллын байгууламжийн засвар, техникийн үйлчилгээ хийх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 28 дугаар, 04.3.3 кодтой Гол замын илчит тэрэгний техникийн байдлыг шалгах хяналтын хуудсыг 29 дүгээр, 04.3.4 кодтой Төмөр замын гармын байгууламж, засвар үйлчилгээ хийх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 30 дугаар, 04.3.5 кодтой Вагоны засвар, техникийн үйлчилгээ хийх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг 31 дүгээр, 04.3.6 кодтой Төмөр замын гүүрийн угсралт, шинэчлэлт, их болон ээлжит засварын ажлыг шалгах хяналтын хуудсыг 32 дугаар, 04.3.7 кодтой Төмөр замын угсралт, шинэчлэлт, их болон ээлжит засварын ажлыг шалгах хяналтын хуудсыг 33 дугаар, 04.3.8 кодтой Төмөр замын ачаа тээвэр, галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалтыг шалгах хяналтын хуудсыг 34 дүгээр, Усан замын хяналтын чиглэлээр 04.4.1 кодтой Усан замын тээврийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсыг 35 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан хяналтын хуудсыг үйл ажиллагаандаа ашиглахад улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Салбарын хяналтын газрын дарга, салбарын улсын ерөнхий байцаагч /Б. Бат-Өлзий/-т үүрэг болгосугай.

3.Хяналтын хуудасны ашиглалт, хяналт шалгалтын явц, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, дүн шинжилгээ хийсэн байдалд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газрын дарга (А.Мөнхбат)-т даалгасугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн “Хяналтын хуудас батлах тухай” А/39 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

С.БАТБОЛД

